



НИЙСЛЭЛИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2015 оны 01 сарын 26 өдөр

Дугаар 29

Улаанбаатар хот

Нийслэлийн Хөдөө аж ахуйн салбарын тэргүүний
хүмүүсийг шалгаруулах тухай

Монгол Улсын Засгийн газрын 2009 оны 70 дугаар тогтоол, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2009 оны 183 дугаар тогтоолоор баталсан “Нийслэлийн тэргүүний тариаланч”, “Нийслэлийн тэргүүний тариаланч хамт олон” шалгаруулах журмын 2 дугаар хавсралтын 4.2 дэх заалт, 2014 оны 221 дүгээр тогтоолоор баталсан “Нийслэлийн тэргүүний фермер” шалгаруулах журмын 5.4, 6.1 дэх заалт, 2014 оны 222 дугаар тогтоолоор баталсан “Нийслэлийн сайн малчин” шалгаруулах журмын 1.3, 4.13 дэх заалтуудыг тус тус үндэслэн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.Нийслэлийн Хөдөө аж ахуйн салбарт олон жил үр бүтээлтэй ажиллаж байгаа Сонгинохайрхан дүүргийн 21 дүгээр хорооны фермер Д.Шаравнямбуу, Б.Мандах, Хан-Уул дүүргийн 14 дүгээр хорооны фермер Х.Ганхуяг, Б.Батмагнай, Налайх дүүргийн 2 дугаар хорооны фермер Т.Чулуунгэрэл, Багануур дүүргийн фермер Т.Баярсайхан, Ш.Батсайхан, Д.Дашрэнцэндорж, “Хишигтэн нүүдэлчин” ХХК-ыг “Нийслэлийн тэргүүний фермер”-ээр, Багануур дүүргийн малчин Ж.Баттулга, Хан-Уул дүүргийн малчин Д.Жамьяншарав, Сонгинохайрхан дүүргийн малчин Д.Алтангэрэл нарыг “Нийслэлийн сайн малчин”-аар, Сонгинохайрхан дүүргийн 21 дүгээр хорооны “Сөөсгөр” ХХК, Хан-уул дүүргийн 13 дугаар хорооны “Сэвсүүл ногоон бүрд” ХХК-ыг “Нийслэлийн тэргүүний тариаланч хамт олон”-оор, Баянзүрх дүүргийн 11 дүгээр хорооны тариаланч Б.Одончулуун, Сүхбаатар дүүргийн 16 дугаар хорооны тариаланч Ж.Наранцэцэг нарыг “Нийслэлийн тэргүүний тариаланч”-аар тус тус шалгаруулсугай.

2.Шагналд зарцуулах санхүүжилтийг Засаг даргын нөөц хөрөнгөнөөс гаргахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч /Э.Бат-Үүл/-д зөвшөөрсүгэй.

